



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД БОЛОН ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД 2023 ОНД ОРОН НУТАГТ БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Дугаар

2023 оны ... дүгээр
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Төрийн албаны тухай, Захиргааны ерөнхий хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Барилгын тухай хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 55 дугаар тэмдэглэл болон тэдгээртэй нийцүүлж гаргасан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутагт боловсрол, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааны зорилт, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн тоо хэмжээ, чанар, үр дүнг үнэлж, дүгнэх, түүнтэй холбоотой үүсэх эрх, үүргийг зохицуулж, тус аймгийн хүн амд үзүүлэх боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх, орон нутгийн хөгжилд шинжлэх ухаан, технологи, инновацийн ололт амжилтыг нэвтрүүлэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайд /цаашид “Сайд” гэх/ болон Дундговь аймгийн Засаг дарга /цаашид “Засаг дарга” гэх/ нар хамтран ажиллахад оршино.



ХОЁР. САЙДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Энэ гэрээний 1.1 дэхь хэсэгт заасан хууль, тогтоомжуудын хэрэгжилтийг хангаж, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын 2023 оны хөгжлийн төлөвлөгөө, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээ, үр дүнгийн хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутагтай хамтран ажиллахдаа дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

2.1.1. Боловсролын салбарын бодлого, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.1.2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулах зорилгоор үндэсний чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулж, үр дүнг үнэлэх, урамшуулалын санхүүжилтийг хийх;

2.1.3. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх, багшийн ажил мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, багшийн ажлын норм, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, ачааллыг бууруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.1.4. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, 5 настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах ажлын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх,

2.1.5. Сургалтын байгууллагын орчинд болон дотуур байранд суралцагчийн эрүүл, аюулгүй сурч, амьдрах, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх;

2.1.6. Боловсролын байгууллагын ажилтан, албан хаагч ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.1.7. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, орон нутгийн хэмжээнд баталгаат хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх, мэргэжлийн хүний нөөцөөр хангахад дэмжлэг үзүүлэх;

2.1.8. Насан туршийн суралцахуйн бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн иргэд сурч, хөгжихөд дэмжлэг үзүүлэх;



2.1.9. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх, асуудлыг Засгийн газар, Улсын Их Хурлаар шийдвэрлүүлж, хэрэгжүүлэх замаар сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.1.10. Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин бүрдүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, багш, ажилтны мэргэжлийн чадварыг тасралтгүй хөгжүүлэх;

2.1.11. Ерөнхий боловсролын сургуульд сурах бичгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх, үнэ төлбөргүй сурах бичгээр бага ангийн нийт суралцагч болон дунд, ахлах ангийн зорилтот бүлгийн сурагчдыг хангах, дижитал сурах бичиг, сургалтын нөөц хэрэглэгдэхүүний нөөцийг бий болгох, ашиглах;

2.1.12. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг нийт багш, ажилтанд төлөвшүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.1.13. Мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад чиглэсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, тэтгэлэг, сургалтын зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.1.14. Салбарын төсвийн төлөвлөлтийг жендерийн мэдрэмжтэй төлөвлөх талаар арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.1.15. Нийтийг хамарсан өвчин тахал, байгалийн гамшиг зэрэг болзошгүй нөхцөл байдлын үед бүх шатны сургалтын байгууллага боловсролын үйлчилгээг тасралтгүй, тэгш хүртээмжтэй хүргэх чиглэлээр хариу арга хэмжээний стратеги төлөвлөн хэрэгжүүлж, теле болон цахим сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах;

2.1.16. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг сургууль завсардахаас сэргийлэх, хоцрогдолгүй сургах, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах;

2.1.17. Шинжлэх ухаан, инноваци, технологийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;



2.1.18. Аймаг орон нутагт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа боловсруулалтын ажилд мэргэжлийн байгууллага, холбоодыг оролцуулах ажлыг зохион байгуулах, судалгаанд суурилсан шийдвэр, инновацийн үйл ажиллагааг дэмжих;

2.1.19. Сайд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт аймгийн Засаг даргаар төлөөлүүлэн хэрэгжүүлэх гэрээний эцсийн хариуцлагыг Засгийн газрын өмнө хүлээнэ;

2.1.20. Засаг дарга нараас ирүүлсэн энэхүү гэрээний хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэн боловсруулах, дүгнэж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д заасан хугацаанд хүргүүлэх үүргийг Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар хүлээнэ;

ГУРАВ. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Боловсрол, шинжлэх ухааны салбарын чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангах, зохицуулах үйл ажиллагааг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд эрхлэн гүйцэтгэж, энэхүү гэрээнд тусгасан үүргийг хэрэгжүүлэн, түүний үр дүнг Сайдын өмнө хариуцна;

3.1.1. Гэрээний 1.1-д заасан хууль тогтоомжийг баримталж, боловсрол, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд мөрдөх Засгийн газрын тогтоол, сайдын тушаал болон тэдгээрт нийцүүлэн гаргасан зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг чанартай, үр дүнтэй зохион байгуулна;

3.1.2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд боловсролын салбарын удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөхөд төрийн албаны талаарх хууль, тогтоомж, дүрэм журмыг мөрдөх, удирдах ажилтны мэргэшсэн байдлыг хангах, тэдгээрийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчил, авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

3.1.3. Энэхүү гэрээний 3.3.1 - т заасан байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, удирдах албан тушаалтны томилгоотой холбоотой асуудлаар шийдвэр гаргахдаа Сайдтай зөвшилцөх үүрэг хүлээнэ;



3.1.4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед бүх шатны сургалтын байгууллага боловсролын үйлчилгээг чанартай, тасралтгүй, тэгш хүртээмжтэй хүргэх чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний стратегийг орон нутагт хэрэгжүүлэх, удирдлагаар хангах, үр дүнг нь бүрэн хариуцна;

3.1.5. Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар жилд хоёроос доошгүй удаа тухайн орон нутгийн боловсролын асуудлыг хэлэлцүүлж гарсан үр дүнгийн дагуу арга хэмжээ авах;

3.1.6. Засаг дарга нь сум, дүүргийн Засаг дарга болон Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, сургууль, цэцэрлэгийн захриалтай энэхүү гэрээг үндэслэсэн үр дүнгийн гэрээг байгуулна;

3.1.7. Тогтвортой хөгжлийн боловсрол 2030, Монгол Улсын санаачлагад тусгагдсан үйл ажиллагаануудыг орон нутгийнхаа хөгжлийн бодлогод уялдуулан хэрэгжүүлж, санхүүжүүлэх;

3.1.8. Хөндлөнгийн болон дотоод аудитаас гарсан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангуулж ажиллах;

3.1.9. Шаардлагатай нөхцөлд төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөн орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллагад аудитын үйл ажиллагаа хэрэгжүүлж, тайланг төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр ирүүлж байх;

3.1.10. Аймгийн боловсролын салбарын барилга байгууламжийн бүртгэлийг жил бүр шинэчилж, ашиглалт хамгаалалтын талаарх мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны яаманд улирал бүр хүргүүлж байх;

3.2. Засаг дарга нь суралцагч, иргэнд тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр дор дурдсан үүрэг хүлээнэ.

3.2.1. Сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын үйлчилгээг салбарын хууль, тогтоомж, шийдвэрийн дагуу тухайн орон нутагтаа зохион байгуулах;

3.2.2. Хичээлийн жилийн бүтцийг мөрдөх, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, сургалтын цахим платформыг хөгжүүлэх, цар тахлын улмаас үүссэн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад тусгайлсан арга хэмжээ хэрэгжүүлэх;



3.2.3. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил, хамгаалал болон сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас авах улсын шалгалт, чанар болон гүйцэтгэлийн үнэлгээ, ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах монгол хэл, бичиг, элсэлтийн ерөнхий шалгалтыг чанартай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.2.4. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн байгалийн ухаан, технологи, инженер, математикийн (STEM) сургалтын хэрэглэглэхүүний ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх

3.2.5. Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлж, 5 настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулахын зэрэгцээ малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих;

3.2.6. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд орчны эрсдэлийн үнэлгээг хийж, сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт, эрүүл ахуйн стандарт болон дотуур байрын орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх;

3.2.7. Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн хангалтгүй байгаа цэцэрлэг, сургуулийн менежементийг сайжруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, багш нарыг сургах, мэргэжлийн бүлгээр ажиллах нөхцлийг бүрдүүлэх ;

3.2.8. Сургалтын байгууллагын интернэт холболтыг сайжруулах, ухаалаг төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх;

3.2.9. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцах, 21-р зууны иргэнд шаардагдах хувь хүний ур чадвар олгох хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.10. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн өөрийн удирдлагын байгууллага, хүүхэд бүрийн хөгжил, хамтын оролцоог дэмжсэн клуб, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжих, энэ чиглэлээр суралцагч, багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.11. МУБИС-ийн Моноцүкүри төвөөс нийлүүлсэн физикийн туршилт хичээлийн хэрэглэгдэхүүнийг сургалтад ашиглахыг дэмжих, байгалийн шинжлэх ухааныг сонгон судлах суралцагчийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх



3.2.12. Сургууль, дотуур байрын орчин дахь хүүхэд хамгааллын асуудалд онцгойлон анхаарч, сургууль, дотуур байрын орчинд хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр компанит, нөлөөллийн ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулах, зөвлөгөө мэдээлэл авах нээлттэй утас байршуулах;

3.2.13. Хичээлээс гадуурх сургалтын ажлыг дэмжих, хүүхдийн оролцоо хэрэгцээнд суурилсан секц, дугуйлангийн нэр төрлийг нэмэгдүүлж, цахим, танхим хосолсон олон талт хэлбэрээр мэргэжлийн байгууллага, мэргэшсэн иргэнтэй хамтарч зохион байгуулах, үр дүнг тооцох;

3.2.14. Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх, тэдэнд холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл, урамшуулах олгох;

3.2.15. Цэцэрлэг, сургуулийн сурагчдын эрүүл ахуйн стандартыг хангуулах, сургууль, цэцэрлэгийн орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх, багш ажилтнууд болон сурагчдын гар угаах, ариун цэврийн орчныг сайжруулах, саван ариутгалын бодисын хангамжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих;

3.2.16. Ахлах ангийн 10-11 дүгээр ангийн цахим сургуульд сонгон судлах хичээлээ судалж буй суралцагчдын ирц, хамрагдалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх

3.2.17. ЕБС-ийн 8-12 дугаар ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох замаар тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад чиглүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх

3.2.18. Цэцэрлэг, сургуульд хүүхэд элсүүлэхэд хандив, хууль тогтоомжид зааснаас бусад төлбөр, хураамж авах, ном, гарын авлага болон бусад сургалтын материал, сонин зэргийг сурагчдад худалдан авахыг шаардахгүй байх;

3.2.19. Суралцагч, багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах;

3.2.20. Багш, удирдах ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцны болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх орон нутгийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;



3.2.21. Аймаг, нийслэлийн хэмжээнд багш, ажилтны ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах, багш, удирдах болон бусад ажилтныг ёс зүйгүй аливаа үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж үр дүнг тооцож ажиллах;

3.2.22. Хууль тогтоомжид заасан онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд багш, нийгмийн ажилтнаар үндсэн чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод үл хамаарах ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхгүй байх;

3.2.23. Багш, удирдах ажилтны мэдээлэл холбооны технологи ашиглах чадвар, цахим контент бэлтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дээрээ хөгжих орчныг бүрдүүлэх, “Багш хөгжлийн төв” -д дэмжлэг үзүүлэх;

3.2.24. Багшийг ээлжит хичээлийн цахим контент бэлтгэх ажилд идэвхтэй оролцуулахад дэмжлэг үзүүлэх, ахлах ангийн суралцагчдыг цахим сургалтын системээр сонгон суралцах боломжийг бүрдүүлэх;

3.2.25. Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж, холбогдох хууль, дүрэм, журамд заасан хугацаанд тайлагнах;

3.2.26. Орон нутгийн иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломжийг олгох, шаардлагатай нөхцөлийг бүрдүүлж, насан туршийн боловсролын төвийг бие даасан байр, танхимтай болгох, иргэнд боловсрол нөхөн олгох ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, тогтмол зардлыг орон нутгийн төсөвт тусгах;

3.2.27. Сургуулийн гадна байгаа хүүхэд болон сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн олгох, тэднийг ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн суралцуулах ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах;

3.2.28. Ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, багш нарыг мэргэжлийн бүлэг байгуулан харилцан бие биенээсээ суралцахад дэмжлэг үзүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

3.2.29. Орон нутаг дахь мэргэжлийн болон дээд боловсролын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ажил олгогчийг татан оролцуулах

3.2.30. Сургалтын байгууллагуудын байр ашиглалт, харуул хамгаалалт, хоол үйлдвэрлэл, ариутгал цэвэрлэгээний болон орон



нутгаас хариуцах бусад үйлчилгээг стандартад нийцүүлэн, тасралтгүй, тогтвортой хангах;

3.2.31. Байрны ашиглалттай холбогдох төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, цалин хөлс, нийгмийн баталгааны нөхцлийг 2022 оноос дордуулахгүй байх, цаашид тогтвор суурьшилтай ажлын байраар хангах;

3.3. Засаг дарга нь боловсролын салбарт менежмент, хүний нөөц, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр дор дурдсан үүрэг хүлээнэ.

3.3.1. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын хүний нөөцийн чадавх болон материаллаг орчныг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тэдний үйл ажиллагааг цэцэрлэг, сургууль, багш нарт мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд бүрэн чиглүүлж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.2. Орон нутгийн өмчийн цэцэрлэг, сургуулийн бүтэц, хэв шинж, орон тооны жишиг норматив, бүлэг дүүргэлтийн стандартыг баримтлан, сургууль, цэцэрлэгийн хэв шинж, стандарт, орон тоо, бүлгийн тооны зохистой байдлыг хангах, ерөнхий боловсролын сургуулийг нэг ээлжинд үе шаттайгаар шилжүүлэх бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.3.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар хангах, ажлын байранд нь мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах ажлыг чанартай зохион байгуулах, дутагдаж байгаа мэргэжлээр орон нутагт шилжин ажиллах багш нарт орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх;

3.3.4. Төсөв, санхүүгийн зарцуулалт, гүйцэтгэлийг Шилэн дансны хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээллэх, дотоод аудитын болон хяналтын тогтолцоог тогтмол ажиллуулах;

3.3.5. Сургалтын байгууллагын эзэмшил газрыг баталгаажуулах, сургууль, цэцэрлэгийн эдэлбэр, эзэмшил газарт зориулалтын бус зөвшөөрөл олгохгүй ашиглуулахгүй байх;

3.3.6. Сургалтын байгууллагын барилгад боловсрол, сургалтын үйл ажиллагаанд ашиглахаас өөр зориулалтаар өргөтгөл



нэмж барихгүй байх, цаг хугацаанд нь ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх, хяналт шалгалт хийх;

3.3.7. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэдээлэл, холбооны дэд бүтэц, сүлжээний төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, сайжруулах;

3.3.8. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нүхэн жорлонгийн тоог цөөрүүлэн стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах арга хэмжээг авч тайлагнах;

3.3.9. Орон нутаг, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй боловсролын салбарын эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хуулиар баталсан зориулалт, хүчин чадал, байршил болон эдийн засгийн ангилалын дагуу зохион байгуулах, хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

3.3.10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн явцад техникийн нөхцөл, зураг төсөл, газрын байршил, хэмжээ, хүчин чадалд өөрчлөлт оруулах, эсвэл шинэ арга хэмжээний боловсруулагдсан эскиз зургийг батлуулах бол төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч байгууллагын зөвшөөрөл авч, хууль тогтоомжид нийцүүлэн зохих шийдвэрийг гаргасан байх;

3.3.11. Орон нутагт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй боловсролын салбарын эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулаагүй, тухайн оны санхүүжилтийг зохицуулалт хийж чадаагүй зэргээс хөрөнгийг татуулсан тохиолдолд Аймгийн засаг дарга нь түүний гэрээний хариуцлага болон санхүүжилтийг шийдвэрлэх үүргийг хүлээх;

3.3.12. Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага” үндэсний стандартын шаардлагад нийцүүлэх, орон нутгийн болон бусад санхүүжилтийн эх үүсвэрээс шийдвэрлэх арга хэмжээ авах;

3.3.13. Ерөнхий боловсролын сургуулийг үдийн хоолны үйлчилгээнд бүрэн шилжүүлж, долоо хоногийн 5 өдөрт халуун хоолоор үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх



3.3.14. Ерөнхий боловсролын сургуулийг стандартын шаардлагад нийцсэн шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангах, хоолны газрын цэвэр усны шугам сүлжээнд шүүлтүүр суурилуулах зэрэг ажилд орон нутгийн болон бусад санхүүжилтийн эх үүсвэрээс шийдвэрлэн хуваарилах;

3.3.15. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хүнсний хангамж, үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүртээмж, орчинд хяналт, үнэлгээ хийх, нэг хүүхдэд ногдох хоолны норматив зардлын зарцуулалт болон хүүхдийн хоол хүнсэнд нийлүүлж буй түүхий эд бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хяналт тавих;

3.3.16. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүнсний хангамжийг сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх, тухайн орон нутгийн хүнсний үйлдвэрлэл, орон нутгийн МСҮТ, ПК-ийг түшиглэн хоолны бэлдэц бэлтгэн нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

3.3.17. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хоол хүнсний үйлчилгээнд оролцогч талуудад хоол шим тэжээлийн боловсрол олгох, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

3.4. Засаг дарга нь шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарыг орон нутагт хөгжүүлэх чиглэлээр дор дурдсан үүрэг хүлээнэ.

3.4.1. Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааг дэмжин ажиллах чиг үүрэг бүхий Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийг Засаг даргын дэргэд байгуулан үйл ажиллагааг дэмжин ажиллах;

3.4.2. Аймаг, орон нутагт шинжлэх ухаан, инноваци, технологийн төслийг дэмжих шаардагдах зардлыг орон нутгийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж, хэрэгжилтийг хангах;

3.4.3. Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх;

3.4.4. Аймаг, орон нутаг, бүсийн түвшинд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудтай хамтран ажиллах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;



3.4.5. Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааг дэмжсэн дэд бүтэц (шинжлэх ухаан, технологи, инновацийн төв, технологи дамжуулах төв, хамтын оффис гэх мэт)-ийг байгуулах, үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авч ажиллах;

3.4.6. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт оруулж буй санхүүжилтийг бүртгэлжүүлэх, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал санаачилга гаргах;

3.4.7. Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, хувийн хэвшилтэй хамтран шинэ санал, санаачилга, хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, грант олгох;

3.4.8. Орон нутгийн иргэдэд шинжлэх ухаан, технологи, инновацийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах;

3.4.9. Тухайн орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан гарааны компанид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг үе шаттай, тогтмол зохион байгуулах;

3.4.10. Аймаг, орон нутгийн онцлогт тулгуурлан байгаль, нийгмийн шинжлэх ухааны танин мэдэхүйн контентыг бүтээж, орон нутгийн болон үндэсний олон нийтийн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэх;

3.4.11. Аймаг, дүүргийн хэмжээнд тулгарч буй асуудлыг шинжлэх ухаанчаар шийдсэн 1 инновацийн төслийг иргэдийн оролцоотой нээлттэй сонгон шалгаруулж, грант олгох ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;

3.4.12. “Тэрбум мод” үндэсний санаачилгын хүрээнд үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран орон нутагт зохион байгуулах;

3.5. Засаг дарга нь боловсролын салбарын санхүү, төсвийн удирдлага, хэрэгжилтийн чиглэлээр дараах чиг үүргийг хариуцна.

3.5.1. Төсвийн тухай хуулийн 14.2.2, 39.4.3 заалт, Боловсролын тухай хуулийн 40.1, 40.2 дахь хэсэгт заасан зохицууллалтыг бүрэн хангаж ажиллана;



3.5.2. Хөрөнгө оруулалтын саналыг Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зураг, төсвийн хамт ирүүлэх;

3.5.3. Ерөнхий боловсрол, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагын хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, тогтмол зардлын өр үүсгэхгүй байх, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний зардлыг хуваарилан хэрэгжүүлэх;

3.5.4. Боловсролын салбарын төсвийн шинэчлэл, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааг дэмжиж ажиллах, холбогдох тооцоо судалгаа, цахим төсвийн төслийн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах;

3.5.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр ажиллах дотоод аудит, хяналт шалгалтын ажлын хэсгийн хүрээнд хөрөнгө оруулалттай холбоотой шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах;

3.5.6. Орон нутаг дахь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийг үндэслэн барилгын угсралтын ажлын явцад техникийн хяналт гүйцэтгэх үүргийг Барилгын хөгжлийн төвөөр гүйцэтгүүлж техник хяналтын зардлын 80%-ийг тус төвийн дансанд, зардлын 20%-ийг захиалагч /БШУЯ/-ийн дансанд шилжүүлж байх;

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТООН БОЛОН ЧАНАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэхэд хавсралтуудад заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэнэ;

4.2. Энэхүү гэрээний хавсралтаар баталсан шалгуурыг хангасан эсэхийг үнэлэхдээ Төсвийн тухай хууль болон боловсрол, шинжлэх ухааны салбарт мөрдөж буй дүрэм, журам, заавар, стандарт, норм холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэнэ;

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ГЭРЭЭГ ДҮГНЭХ

5.1. Гэрээний биелэлтийг зүйл, заалт нэг бүрээр чанартай боловсруулан хагас жилийн тайланг 2023 оны 7 дугаар сарын 15-ны

дотор, бүтэн жилийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор Боловсрол, шинжлэх ухааны яаманд ирүүлнэ;

5.1.1. Жилийн эцсийн тайланд хяналт шинжилгээ , үнэлгээ хийсэн байх

5.1.2. Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргуулан баталгаажуулсан байх;

5.1.3. Аймгийн боловсролын газруудын дотоод хяналтын сайжруулж, хагас бүтэн жилээр хийсэн дотоод хяналтын ажлын тайланг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Боловсролын ерөнхий газарт ирүүлдэг байх;

5.2. Үндэсний статистикийн хорооноос баталсан маягтын дагуу мэдээлэл, тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж, холбогдох газарт хүргүүлэх, байгууллага, иргэдийг мэдээллээр хангах;

5.3. Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, Их дээд сургууль, коллежийн хүний нөөц, суралцагчид, тоног төхөөрөмжийн мэдээ, мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын мэдээллийн технологийн төвийн мэдээллийн цахим системд тухай бүрт тайлагнах;

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

6.1. Энэхүү гэрээ нь 2023 оны төсвийн жилийн хугацаанд үйлчилнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ГАРЫН ҮСЭГ

7.1. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Дундговь аймгийн Засаг дарга нар Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцсөний үндсэн дээр гарын үсэг зурж байна;

НАЙМ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

8.1. Гэрээний зүйл, заалтад тодорхой нөхцөл байдлын улмаас өөрчлөлт орсон тохиолдолд аль нэг талаас гаргасан хүсэлтийг үндэслэн өөрчлөлт оруулж болно. Үүнд:

8.1.1. Гэрээний зүйл, заалт хэрэгжих боломжгүй маргаантай асуудал үүссэн,

8.1.2. Гэрээ байгуулсан эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн,



8.1.3. Гэрээнд зүйл, заалттай холбогдсон хууль тогтоомжийн заалтад өөрчлөлт орсон,

8.1.4. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн тохиолдсон гэж талууд хүлээн зөвшөөрсөн тохиолдолд.

8.2. Гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг баталгаажуулан гарын үсэг зурж, хоёр хувь үйлдэх бөгөөд энэхүү өөрчлөлт нь анхны гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ;

ЕС. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

9.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зуран, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.2. Энэхүү гэрээний хавсралт гэрээний салшгүй нэг хэсэг болно.

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

**ЛУВСАНЦЭРЭН ОВОГТОЙ
ЭНХ-АМГАЛАН**

**ЦАГААНХҮҮ ОВОГТОЙ
МӨНХБАТ**

.....

.....

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД БОЛОН ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД 2023 ОНД ОРОН НУТАГТ БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны зори лтот түвш ин
	1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ	



1.1	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь (2-5 нас)	74.15
1.2	5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь	92
1.3	Малчин болон алслагдсан хязгаар бүсэд амьдарч буй өрхийн 3-5 насны хүүхдэд зориулан нийлүүлсэн гэр цэцэрлэгийн тоо	2
1.4	Цэцэрлэгийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн СӨБ-д хамрагдалтын дундаж (хувиар)	40.4
1.5	Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан цэцэрлэгийн багшийн тоо	12.5
1.6	Цэцэрлэгт ажиллуулсан ээлжийн багшийн тоо	1
1.7	Цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	88.9
1.8	Цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	87.8
1.9	Ашиглалтад орох цэцэрлэгийн тоо / барилга эхлэх цэцэрлэгийн тоо 2/	0
1.10	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах цэцэрлэгийн тоо/ яамны төлөвлөгөөнд тусгагдсан тоогоор/	1
2. БАГА, ДУНД БОЛОВСРОЛ		
2.1	Бага, дунд боловсролын чанарын дундаж үнэлгээ, хувиар	43.65
2.2	Сургуулийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ЕБ-д хамрагдалтын хувь	45
2.3	Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	56.45
2.4	Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	28.95
2.5	Дунд, ахлах ангийн сурах бичгийн хангалтын хувь	88
2.6	Үдийн хоолны үйлчилгээнд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн тоо /Бага ангийн сурагчдыг оруулав/	4422
2.7	Стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин бүрдүүлсэн сургуулийн эзлэх жин	43.3
2.8	Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	73.65
2.9	ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	73.5
2.10	Компьютероор хангагдсан ЕБС-ийн багшийн эзлэх жин	61.5
2.11	Нэг компьютерт ногдох суралцагчийн тоо	30.95
2.12	Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж	517.9
2.13	Дотуур байранд суух хүсэлтийн дагуу амьдарч байгаа суралцагчийн хувь	98.8
2.14	Нийгэм, сэтгэл хөдлөлийн ур чадвар хөгжүүлэх хичээлээс гадуурх сургалтад хамрагдсан ЕБС-ийн дунд, ахлах ангийн суралцагчийн эзлэх жин	26



2.15	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах ерөнхий боловсролын сургуулийн тоо / 4-р ээлжийн сургуулиудыг оруулахгүй /	16
2.16	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах дотуур байрны тоо	2
2.17	Ашиглалтад орох сургуулийн тоо	1
2.18	Ашиглалтад орох дотуур байрны тоо	0
3. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ		
3.1	Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь	2.65
3.2	Тухайн орон нутаг дахь МБСБ-ын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин	68
4. ДЭЭД БОЛОВСРОЛ		
4.1	Тухайн орон нутгаас ДБСБ-д тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр элсэн сурсан элсэгчийн нийт элсэгчид эзлэх жин	40.5
4.2	Дотоодын болон гадаадын их дээд сургуульд суралцах тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн тоо /ерөнхийлөгчийн тэтгэлэг/	12
5. НАСАН ТҮРШИЙН БОЛОВСРОЛ		
5.1	Цахим ур чадвар олгох сургалтад хамрагдсан 25-45 насны иргэдийн тоо	500
5.3	Бие даан олж авсан мэдлэг, ур чадвараа үнэлүүлж, баталгаажуулсан иргэний тоо	50
6. ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦИ		
6.1	Хэрэгжүүлсэн шинжлэх ухаан, технологийн төсөл /судалгаа хөгжүүлэлт/-ийн тоо	1
6.2	Шинжлэх ухаан, технологийн төсөл /судалгаа хөгжүүлэлт/-д зарцуулсан санхүүжилтийн хэмжээ сая.төг /тоо, хувь/ (Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй хасуулах саналтай байна)	50
6.3	Хэрэгжүүлсэн мэдээлэл, технологийн инновацийн төслийн тоо	1
6.4	Инновацийн төсөлд зарцуулсан санхүүжилтийн хэмжээ /тоо, хувь/ (Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй хасуулах саналтай байна)	100
6.5	Гарааны компаний тоо /гарааны бизнесийн үйл ажиллагааны чиглэл/	1
6.6	Гарааны бизнесийг дэмжсэн /санхүүжилт/-ийн хэмжээ (Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй хасуулах саналтай байна)	50
6.7	Шинжлэх ухаан, технологийн үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, зохион байгуулсан арга хэмжээний тоо	1
6.8	Шинжлэх ухаан, технологийн үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, зохион байгуулсан арга хэмжээнд	10



	зарцуулсан санхүүжилтийн хэмжээ (Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй хасуулах саналтай байна)	
6.9	аймаг, нийслэлийн Засаг даргын/ орон нутгийн тухайн жилийн төсвөөс шинжлэх ухаан, технологийг орон нутагт хөгжүүлэх, дэмжихэд зарцуулсан санхүүжилтийн хэмжээ (Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй хасуулах саналтай байна)	0.01
6.10	Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлсэн байдал	2

---oOo---

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД БОЛОН ДУНДГОВЬ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД 2022 ОНД ОРОН НУТАГТ
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРТ ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХОЁРДУГААР ХАВСРАЛТ**

**НЭГ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭРХ
ШИЛЖҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/430 тоот тушаалаар эрх шилжүүлсэн.

Д/ д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөв т өртөг /сая.төг/ г/	2022 онд санхүүж их дүн /сая.төг/
			Эхлэх	Дуусах		



**ХОЁР. ДУНДГОВЬ АЙМАГТ ТҮЛХҮҮР ГАРДУУЛАХ
ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛТЭЙ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, ДОТУУР
БАЙРНЫ НҮХЭН ЖОРЛОНГ АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖААР СОЛИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Д/ д		Төсөлд хамрагдах байгууллагын нэр	Хугацаа	Төсөв т
---------	--	--------------------------------------	---------	------------



	Сум, багийн нэр				өртөг /сая.тө г/
			Эхлэх	Дууса х	
1 дүгээр ээлж					
2 дугаар ээлж					
1					
2					
3					

---oOo---



**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД БОЛОН ДУНДГОВЬ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД 2022 ОНД ОРОН НУТАГТ
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРТ ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ГУРАВДУГААР ХАВСРАЛТ**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНЭЭС АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ЗАГВАР

	Үндэслэж буй бодлогын баримт бичиг	Санхүүжилт н эх үүсвэр	Шалгуур үзүүлэл	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин
1	Зорилт 1					
1.1.	Арга хэмжээ					
1.2.	Арга хэмжээ					
1.3.	Арга хэмжээ					

---oOo---